



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 1/173

Арвайхээр

Тэндерийг хүчингүй болгож, шууд гэрээ
байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 80 дугаар дүгнэлтийн дагуу Арвайхээр сумын дайргын голын ногоочдын цахилгаан шугам тавих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер (ӨВАОНӨГ/201904037)-т шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул хүчингүй болгосугай.

2. Дээрх тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шууд гэрээ байгуулан ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100814

D:My Doc. Zahiramj. Zasag darga